Ёс зүйн хорооны 2025 оны 12-р сарын
01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/”-ийг баталсантай уялдуулан тус хорооноос “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулж, батлан 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар баталж аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”-ны дагуу: 1.Засгийн газрын 2024 оны 109 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах зорилгоор дуу, дүрс бүхий мэдээлэл бэлтгэж хийж, байгууллагын сайтад 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байршуулсан. 2.Улсын бүртгэлийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулах Удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 06, 03 дугаар сарын 24, 09 дүгээр сарын 22-ны өдрүүдэд нийт 39 шинэ албан хаагчдад “Төрийн албан хаагчийн харилцаа, төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлийн хэлбэрүүд” сэдвээр тус хорооны нарийн бичгийн дарга Э.Сувд-Эрдэнэ, гишүүн Э.Батцэнгэл нар 3 удаагийн сургалтыг хийсэн. 3.2025 оны 2 дугаар улирлын байдлаар "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 20 гомдлын шийдвэрлэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин шалгаж, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцсэн. Дээрх гомдлоос 6 гомдлыг үндэслэлгүйгээр хааж шийдвэрлэсэн нэгжүүдэд холбогдох мэдээллийг хүргүүлсэн.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Тайлант хугацаанд тус хороо нь 14 удаа хуралдаж, ёс зүйн зөрчилтэй гэх 21 гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэсэн бөгөөд “Ёс зүйн зөрчилд тооцох тухай” - 9, “Ёс зүйн зөрчилд тооцохгүй тухай” - 12 дүгнэлтийг гаргаж, албажуулан томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний дагуу:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2024 оны 05 дугаар тогтоолын хасвралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу дараах арга хэмжээг авч ажиллаа:

1/Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримталдаг, удирдлага, хамт олны эерэг хандлага, харилцаанд анхаардаг хамт олныг шалгаруулах зорилготой 2025 оны Ёс зүйтэй хамт олныг шалгаруулах удирдамжийг 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр батлуулан аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст болон зохион байгуулалтын нэгжүүдэд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн. Удирдамжид зааснаар 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дотор нэгжүүдээс тайлан мэдээллийг хүлээн авч нэгтгэж, дүгнэсний дагуу 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Ёс зүйтэй хамт олныг шалгаруулан ажилласан.

2/Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллах удирдамжийг батлан ажилласан бөгөөд Ёс зүйн дэд хорооны дарга С.Оюунгэрэл, гишүүн Б.Должинсүрэн, Б.Отгон, Э.Батцэнгэл, нарийн бичгийн дарга Э.Сувд-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 08 дугаар сарын 08, 22-ны өдрүүдэд Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж, ёс зүйн зөрчил, анхаарах асуудлын хүрээнд сургалтыг зохион байгууллаа. Сургалт, мэдээллийн хүрээнд хэлтсийн удирдлагатай уулзаж, ёс зүйн манлайллын талаар болон нэгжийн хэмжээнд нөлөөллийн ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл солилцож, нийт 39 албан хаагчийг хамруулан хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд юуг анхаарах талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, “Улсын бүртгэлийн байгууллагын соёл, ёс зүйн үнэт зүйл”-ийг танилцуулсан. Мөн үйлчилгээний танхимд улсын бүртгэлийн үйлчилгээ авч буй иргэдээс “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх иргэдийн үнэлгээний судалгаа“-г авсан бөгөөд судалгаанд нийт 41 иргэн оролцсон байна.

3/Монгол Улсын Ёс зүйн хорооноос Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”(2024-2030)-ийн холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 1/10656 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

4/Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Монгол Шведийн хамтын нийгэмлэг" төрийн бус байгууллагын дэргэдэх "Сэтгэл зүйн сургалт, хөдөлгөөнт дасгалын Д&C төв"-тэй хамтран "Албан хаагчдын харилцаа, хандлага" сэдвээр үе шаттай сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Эхний сургалтыг 2025

оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулалтын нэгжийн 40 албан хаагчийн дунд зохион байгуулсан бол 2025 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 70 албан хаагчийг хамруулан сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтаар хувь хүнд шаардагдах хэрэгцээт сэтгэл зүйн мэдээллийг өгч, өөрөө өөрийгөө танин мэдэх, аливаа зүйлийг эерэгээр харахад туслах, сэтгэл зүй эерэг байснаараа харилцаа, хандлагад хэрхэн нөлөөлдөг талаарх мэдээллийг өгсөн.

5/Тайлант хугацаанд тус хороо нь 14 удаагийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар ёс зүйн зөрчилтэй гэх 22 гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэж Ёс зүйн зөрчилд тооцох тухай 9, тооцохгүй тухай 12 дүгнэлтийг гаргаж, албажуулан томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 1 гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн дагуу иргэн нь буцаан авсан.

6/Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар болон хүлээн авсан гомдол, мэдээллийг хэрхэн шийдэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршлуулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Улсын бүртгэлийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос тус байгууллагын 2025 оны “Ёс зүйтэй хамт олон”-ыг шалгаруулах тухай удирдамж батлуулсны дагуу байгууллагын дотоод соёлд ёс зүйн үнэт зүйлийг төлөвшүүлэх, ажлын орчинд харилцан хүндэл, шударга ёсыг дэмждэг хамт олныг нийтэд таниулах, мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг мөрдөх, удирдлага, хамт олны уур амьсгал эерэг, харилцаа хандлага бий болсон.	-

Санал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлагыг тус хуулийн 8 дугаар зүйлд, ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөн хуулийн 7 дугаар зүйлд тус тусад нь зохицуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж зохицуулсан буюу 8 дугаар зүйлд заасан 8 төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчсөн зөрчил нь ёс зүйн зөрчил гэх ойлголтод хамаарч байгаа нь учир дутагдалтай байна.

Тодруулбал, албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь ёс зүйн нийтлэг шаардлага буюу ёс зүйн зөрчилд хамаарахгүй байгаа нь Ёс зүйн дэд хорооны хурлаар гомдол, мэдээлэл хэлэлцэх үед тухайн үйлдэл нь ёс зүйн нийтлэг хэм хэмжээг зөрчсөн үйлдэлд хамаарч байгаа хэдий ч нийтлэг шаардлагыг зөрчөөгүй буюу ёс зүйн зөрчил гаргаагүй гэх агуулгаар Ёс зүйн зөрчилд тооцохгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

Шалгах хэсэг:

- ✓ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА /...../ Д.ДАВААНЯМ

Ёс зүйн дэд хорооны дарга:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН
АРХИВЫН ГАЗРЫН ДАРГА /...../ С.ОЮУНГЭРЭЛ

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:
ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН /...../ Э.БАТЦЭНГЭЛ

Огноо: ..... оны ..... сарын .....

Ёс зүйн хорооны 2025 оны 12-р сарын
01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

2025 оны 12 дугаар сарын 31 Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сургийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батландсан агуулгын хүрээнд зохион байгуулсэн эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

БАТЛАВ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА С.ОЮУНГЭРЭЛ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.12.04

д/д	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	Хамт олны санал асуулгаар тодорхойлсон Улсын бүртгэлийн байгууллагын ёс зүй, соёл, үнэт зүйлийн тухай ойлголтыг сурталчлан таниулах	-	Сурталчилан таниулсан арга хэмжээний тоо	-	2	II улирал	Гишүүд
2	Ёс зүйн түвшин тогтоох судалгаагаар хангалтгүй үнэлэгдсэн нэгжүүдэд ажиллах	Улсын төсөв	Дэд хорооны бүрэлдэхүүн ажлын байранд очиж ажилласан нэгжийн тоо	-	4	I-IV улирал	Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
3	Засгийн газрын 11-11 төвд ирүүлсэн ёс зүйтэй холбоотой гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	-	Хяналт тавьж ажилласан хувь	27/100	100	I-IV улирал	Гишүүд
4	Ёс зүй, харилцаа, хандлагын талаар мэдээлэл, видео, контентыг хийж, байгууллагын цахим хуудсаар сурталчлах	-	Цахим хуудсаар сурталчилсан видео контентын тоо	-	2	I-IV улирал	Гишүүд
5	Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар болон хүлээн авсан гомдол, мэдээллийг хэрхэн шийдэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах	-	Цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоо	5	7	I-IV улирал	Нарийн бичгийн дарга

6	Дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх	-	Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн хувь	100 /15/	100	I-IV улирал	Гишүүд
			Ёс зүйн зөрчилд тооцох тухай дүгнэлтийн хувь	100 /10/	100		
			Ёс зүйн зөрчилд тооцохгүй тухай дүгнэлтийн хувь	100 /5/	100		
7	Албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага", "Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйт манлайлал, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" зэрэг сэдвээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	32	40	I-IV улирал	Гишүүн Б.Байгалмаа
			Зохион байгуулсан сургалтын тоо	-	2		
8	Ёс зүйн зөрчилгүй нэгжийг шалгаруулах, шалгуур үзүүлэлтийг дэд хорооны хурлаар хэлэлцэн батлаж, шалгаруулах. /Шалгарсан нэгжийг урамшуулах/	Улсын төсөв	Хангалттай үнэлгээ авсан нэгжийн хувь	35.8 /14 нэгж/	50	IV улирал	Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
9	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ёс зүй болон ёс зүйн зөрчилгүй хамт олныг шалгаруулах судалгааг хөндлөнгийн мэргэшсэн байгууллагаар хийлгэх	Улсын төсөв	Мэргэшсэн байгууллагаар хийлгэсэн судалгааны тоо	-	1	III-IV улирал	Гишүүд
10	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн харилцаа, хандлагын талаар судалгаа явуулж, хөндлөнгийн судалгаа хийлгэсэн байгууллагатай харьцуулах, дүн шинжилгээ хийх	-	Харьцуулсан дүн шинжилгээ хийсэн тоо	-	1	III-IV улирал	Гишүүд, нарийн бичгийн дарга
11	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга Ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж, арга зүйн зөвлөгөө авах	-	Хамрагдсан сургалтын тоо	-	2	I-IV улирал	Нарийн бичгийн дарга
12	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх	Улсын төсөв	Судалсан олон улсын байгууллагын тоо	-	1	I-IV улирал	Гишүүд

	хүрээнд сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар судлах, (Шаардлагатай тохиолдолд гадаад улсын туршлага судлах сургалтад хамрагдах)						
13	Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдын мэдээллийг хагас бүтэн жилээр гаргаж Тамгын газарт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	-	Тайлан мэдээг гаргаж хүргүүлсэн тоо	4	4	I-IV улирал	Нарийн бичгийн дарга

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО